

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМ

БАТЛАВ:ЗАСАГ ДАРГА

Ж. СУХБААТАР

УХААЛАГ ХУДАГТ УС ЦЭВЭРШҮҮЛЭХ ТӨХӨӨРӨМЖ  
ТАВИХ

/Төндерийн баримт бичиг/

Төслийн нэр: **ухаалаг худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж тавих**

Төслийн дугаар: ХА-2020/02

ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

2020 он

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо:2020-07-07

Тендер шалгаруулалтын нэр: **Сумын төвд ухаалаг худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих**

Тендер шалгаруулалтын дугаар: **ХА-02/2020**

**Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын Тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос сумын төвд ухаалаг худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих** худалдан авах ажил гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг **/хүсвэл нэмэлт хувийг/** бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50.000** төгрөгөөр худалдан авч болно. Тендер нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд

Борлуулалтын хэмжээ: **40 сая төгрөг**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **25 сая төгрөг**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:2

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **60 сая төгрөг**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2 /ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ/ -д заасан тусгай зөвшөөрөлтэй байх.

Тендерийн хамт **180,000** төгрөгний дүнтэй **/1 хувийн /** тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 00** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 30** минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**

**Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцно.**

Төлбөрийн хийх хэлбэр : **Дансаар тушаана.**

Банкны нэр: **Төрийн сан банк**

Дансны дугаар **#100060755406**

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь аймгийн Өргөн сумын Засаг даргын Тамгын газар Утас:  
Б.Мөнхбаатар:96193777 Э.Мөнх-Эрдэнэ: 94448804, 89198804 1 давхар 101 тоот  
**өрөө**

## **Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

Эрх бүхий тендерт оролцогч	Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
Тендер ирүүлэх, тендерийн нээлт	Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
	Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
Тендерийн иж бүрдэл	Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ: (а) Үнийн санал; (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь; (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг; (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
Тендерийн үнэ	Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
	Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал

болгож болно.

Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

Үнийн саналын хүчинтэй байх  
хугацаа

Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Алдааг  
залруулах

Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх	Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
	Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл	Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫ ХОЛБОГОДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.</p> <p>Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл ирүүлнэ. /гэрээгээр гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</p> <p>Тухайн байгууллагын даргын цахим үнэмлэхний баталгаажуулсан хуулбар</p> <p>Төлөөлөх этгээдийн итгэмжлэл</p> <p>Татварын болон нийгмийн даатгалын эрх бүхий даргын гарын үсэгтэй тодорхойлолт</p> <p>Ажилчдын мэргэжил, ур чадварын мэдээлэл</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2 /ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ/ -д заасан тусгай зөвшөөрөлтэй байх.</li> </ol> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li></li> </ol>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Дорноговь аймгийн Өргөн сум 4 дүгээр баг найрамдал хороо Засаг даргын тамгын газрын 1 давхар 101 тоот, 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдөр</p> <p>Байгууллагын хаяг: Дорноговь аймаг Өргөн сум 4 дүгээр баг найрамдал хороо ЗДТГ-ын 101 тоот</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Засаг даргын Тамгын газрын 1 давхар 101 тоот</p> <p>Огноо: 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдөр</p>

	Цаг: 10 цаг 00 минут
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Дорноговь аймаг Өргөн сум 4 дүгээр баг найрамдал хороо ЗДТГ-ын 101 тоот</p> <p>Байгууллагын хаяг: Дорноговь аймаг Өргөн сум 4 дүгээр баг найрамдал хороо ЗДТГ-ын 101 тоот</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Засаг даргын Тамгын газрын <b>1 давхар 101 тоот</b></p> <p>Огноо: 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Ухаалаг худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж тавих</b> ажил</p>

**Дөрөв. УХААЛАГ УС ТҮГЭЭХ БАЙРНЫ ТӨХӨӨРӨМЖ ШИНЭЧЛЭХ ХАЛУУН  
ХҮЙТЭН ЦЭВЭРШҮҮЛСЭН УСНЫ ГУРВАН ТАРИФТАЙ УС ТҮГЭЭХ  
БОЛОМЖТОЙ БОЛГОХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Тоноглолт	Техникийн шаардлага /доод үзүүлэлт /
Удирдлагын товчлуур	Гаднаас хэрэглэгч шууд удирдах боломжтой, эвдрэл байхгүй, хэрэглэхэд хялбар, цельсийн -50с-аас +45с градуст хэвийн ажилладаг байх
Ашиглалтын заавар	Гадна хананд хэрэглэгчдэд зориулан харагдахуйц газар системийг ашиглан усаа авах заавар санамж болон анхааруулга тавигдана.
Удирдлагын процессор	Мэдээлэл боловсруулалт хийх болон серверт холбогдох, худгийн төхөөрөмжийг удирдах тоноглолт бүхий самбартай байх. Температурын болон хүчдэлийн өөрчлөлттэй үед ч ажиллагааны хэвийн горимд баазтай байх ба OFFLINE үед усаа түгээж ажиллах, ONLINE болсон үед автоматаар хэвийн горимд шилждэг байх. Худгийн систем өөр дээрээ SQLite 3.0 дээр хийгдсэн дотоод мэдээллээ төв серверт илгээдэг байх Windows 7/8/10 үйлдлийн систем суудаг байх. Microsoft.NET 4.5 болон түүнээс дээш хувилбар дээр хийгдсэн Desktop Form Application дэмждэг байх. Хэрэглэгчид Video, Audio мэдээлэл шууд хүргэх боломжтой байх.
Автомат хаалт	Хэвийн горимт нөхцөлд 2.5 сая литр ус нэвтрүүлэх ашиглалтын хугацаатай ба үүнээс ч цааш ашиглах боломжтой. (DN15-25mm Press 0-10kgf/Cm2)
Усны тоолуур	Механик болон элекрон хосолсон ба нарийвчлал 1 литр
Дотор сантехник холболт	Худгийн онцлогоос хамаарч төвийн шугмаас тоног төхөөрөмжөөр дамжиж хэрэглэгчид хүртэл хийгдэх цэвэр усны сантехник холболтыг хийж гүйцэтгэнэ.
Программ хангамж	Программ хангамж нь усны хэрэглээ болон зарцуулалт цэнэглэлтийн мэдээллийн санг үүсгэж серверт мэдээлэл боловсруулалт хийх анализ хийх график болон бусад тайлан гаргах

	боломжийг олгосон байх. Мөн нэг картаар аль ч худгаас ус авах боломжийг хэрэглэгчид олгоно. Одоо диспетчер дэлгэцээс худгуудын бүх мэдээллийг хянах боломжийг олгосон бөгөөд дэлгэцэнд тухайн худгаар үйлчлүүлсэн хэрэглэгчийн тоо, худаг бүрийн зарцуулсан литр, аюулгүй ажиллагааны хэрэгслүүд ажилласан эсэх худгийн температурын мэдээллийг харуулах. Одоо ашиглаж байгаа баазтай харилцаж мэдээллээ солилцдог байх
Online Server	Мэдээллийн нэгдсэн сан худгуудыг удирдлагаар хангах, гуравдагч системүүд холбогдох, худгуудаас мэдээлэл цуглуулах, хуваарилах зэргийг хийж гүйцэтгэх үүрэгтэй. Мөн тайлан, статистик, динамик мэдээ тайлан боловсруулах, мониторингийн системийн мэдээллээр хангах үүрэгтэй. Ашиглалтад хялбар байх үүднээс диспетчерт усаа авч буй агшнийг харуулах, зөөврийн худгуудын усаа дууссан мэдээллийг диспетчер харах боломж олгосон байх
Агшин зуурын ус халаагч	Хүчин чадал -5к  Хүчдэл -220в
Бойлер	<ul style="list-style-type: none"> <li>• Термометр болон термостат тохируулагчтай байх</li> <li>• Өөр дээрээ аноджуулсан магнийн элементтэй зэврэхгүй байх</li> <li>• Үл буцах хаалттай байх</li> <li>• Хүчин чадал 1,5квт -2квт цахилгаан бага зарцуулдаг байх</li> <li>• Дээд температур 80<sup>0</sup> С</li> <li>• Доод температур 50<sup>0</sup> С</li> <li>• Усны багтаамж 100 литрээс багагүй байх</li> <li>• 15<sup>0</sup> С - 80<sup>0</sup> С хүртэлх халах хугацаа 151 минутаас ихгүй байх</li> <li>• Даралттай шугамын дунд суурилуулна.</li> </ul>
Ус цэвэршүүлэгч шүүлтүүр	Хамгийн их даралт 100bar  Дээд температур 49 <sup>0</sup> С  Доот температур 1 <sup>0</sup> С

	<p>24 цагт 2000 литрээс багагүй ус боловсруулах хүчин чадалтай усан дахь зэв органик бодис колloid, элс шавар, нүдэнд үл үзэгдэх тоосонцор, хлор, хүнд металлыг шүүж нян бактерийг устгаж, усны элдэв амт, өнгө үнэрийг арилгаж хүний биед зохимжтой, эрүүл цэнгэг усыг боловсруулж гаргана.</p> <p>Өөрөө өөрийгөө угаас цэвэрлэдэг байх</p> <p>Хатуулаг бууруулдаг KU2 бодисоор цэнэглэгддэг байх</p>
Усны шланк	<p>Иргэд усаа авч дууссан үедээ буцаа шланкаа хийдэг байхаар гүйцэтгэх</p> <p>/усны шланк нь хөлдөж хугардаггүй, сайн чанарын байх/</p>

Эдгээр төхөөрмж нь өндөр хүчин чадалтай тул цахилгаан хэлбэлзэггүй, хүчин чадалдаа хүрдэг газар суурилуулах шаардлагатай. Цахилгааны хүчдэл 220В болон 330В хүрэхгүй улмаас хүсэмжит температурт халахгүй байх, төхөөрмжийн халаах элемент шатах зэрэг асуудал гарах болзошгүй тул цахилгааны эх үүсвэртээ анхаарна уу.

Техникийн тодорхойлолт боловсруулсан

Үнэлгээний хорооны дарга:

Нарийн бичиг .....

Гишүүд.....

## Тав. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарыт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарыт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарыт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарыт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарыт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн

үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

*Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулаагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.*

## Зургаа. ЖИШИГ МАЯГТ

### ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендериийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.

Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.

Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх	Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
Төслийн менежерийн шийдвэр	Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх	Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
Аюулгүй байдал	Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
Зааварчилгаа	Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
Маргааныг шийдвэрлэх	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ	
Ажлын	Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл

хөтөлбөр	ажиллагааны өрөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
Зөрчил, гологдол илрүүлэх	Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
Зөрчил, гологдол арилгах	Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
Зөрчил, гологдол арилгахгүй байх	Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.
Үе шатны ажлын хуваарь	B. ЗАРДЛЫН ХЯНАЛТ Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

и魯үлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.

Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж и魯үлнэ.

Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх Алданги Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

Алданги Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

#### Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

Ажил дуусгах Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.

Хүлээж авах Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

Эцсийн тооцоо Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.  
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

Ашиглалт,  
засвар,  
үйлчилгээний  
гарын авлага

Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

Гэрээг цуцлах

Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоо тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоо тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоо зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**

Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**Гүйцэтгэлээс чөлөөлөх**

Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Ухаалаг худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих ХА-2020/02
ГЕН 2.1	Ажил нь ухаалаг худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж тавих Ажлын талбай нь: Өргөн сумын Засаг даргын тамгын газар
ГЕН 3.1	Төслийн менежер нь Өргөн сумын ЗДТГ-н дарга О.Цасанцэцэг хаяг/ баатарийн талбай
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр:2020.07.22 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр:2020.08.05
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 730 хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,1 хувь байна. <sup>4</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 0 байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 2020.07.22-ний дотор гаргаж өгнө.

Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [мөнгөн дүн] байна.

ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 180,000 төгрөг байна.
----------	--

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

<sup>4</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_  
хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр  
эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана,  
\_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_

барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг  
инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан  
хангамж/, туслах барилга /бусад ажил/-ын хамт  
оны дугаар сарын -ны өдөр эхэлж, оны дугаар сарын -  
ны өдөр ашиглалтад оруулна.

Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Бусад шаардлагатай баримт бичиг ;

Үнийн санал

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт;

Зураг

Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :

Санхүүжилтийн хуваарь;

Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын

үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны  
дугаар]

үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны  
дугаар]